

Маргааны товч

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Байгаль орчны газрын хяналтын улсын байцаагчийн 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 0049040 дүгээр шийтгэлийн хуудсаар “Магнайтрейд” ХХК-ийг Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил үйлдсэн гэж үзэн, 3,000,000 төгрөгөөр торгож, 875,966,100 төгрөгийг улсын орлого болгохоор шийтгэл оногдуулжээ.

“Магнайтрейд” ХХК-аас дээрх шийтгэлийн хуудсыг эс зөвшөөрч, хүчингүй болгуулах шаардлага бүхий гомдол гаргаж, үндэслэлээ “... 2021 онд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон 2021-2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хийлгэж, яамаар батлуулан үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд үнэлгээний тайлан, төлөвлөгөөг зөрчил шалган шийдвэрлэх явцад танилцуулсан байхад Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу торгож шийтгэсэн нь хууль зүйн үндэслэлгүй, мөн шийтгэлийн хуудсаар хууль бус орлого болох 875,966,100 төгрөгийг улсын орлого болгохоор шийдвэрлэхдээ тус орлогын хэмжээг хэрхэн яаж тогтоож, нотолсон нь тодорхойгүй байгаа нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн, компанийн эрх ашгийг хохироосон, хариуцагчаас шийтгэл оногдуулахдаа тогтоох шаардлагатай нөхцөл байдлуудыг бүрэн тогтоогоогүй” гэж;

Хариуцагчаас “... 2024 онд тус компанийн Сэлэнгэ агуулахын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх явцад тухайн жилийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй, төлөвлөгөөнд орсон ажлуудыг хугацаанд нь бүрэн хийж холбогдох төрийн байгууллагад тайлангаа хүргүүлж баталгаажуулаагүй нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.5, 9.6-д заасныг зөрчсөн гэж үзэн Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шийтгэлийн хуудас оногдуулж, хууль бус орлогыг улсын орлого болгохоор шийдвэрлэсэн, хуульд зааснаар жил бүр тайлагнаж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулаагүй учраас 2021-2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нь хүчингүй гэж үзэж шийтгэл оногдуулсан ...” гэж тус тус тайлбарлан маргажээ.